НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 03 сарын 09 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ,
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"2. Зам, тээврийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд болон замын хөдөлгөөнд оролцогч талуудын мэдээлэл солилцох чадварыг технологийн тусламжтайгаар сайжруулж замын хөдөлгөөнийг хянах, удирдах, дүн шинжилгээ, төлөвлөлт хийх "Зам, тээврийн нэгдсэн систем" төслийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн танилцуулгыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга О.Чинзориг танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Зам, тээврийн нэгдсэн системд шаардлагатай бодит мэдээ мэдээллийг түргэн шуурхай гаргах, системүүдийг нэгтгэж холбоход дэмжлэг үзүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;

2.Зам, тээврийн нэгдсэн системийн хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын мэдээллийг улирал бүр тайлагнаж ажиллахыг Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (Ч.Батзориг)-д;

3.Нийслэлийн Зам, тээврийн нэгдсэн систем бий болсонтой холбоотой хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн батлуулах ажлыг чиг үүргийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс (Г.Содбаяр)-т;

4.Улаанбаатар хотын авто замын газрын зургийн суурь системд нийтийн тээврийн бодит цагийн мэдээллүүдийг холбож 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөрт багтаан хэрэглээнд нэвтрүүлэхийг Нийслэлийн Нийтийн тээврийн газар (С.Жавхлантбаатар), Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг) нарт;

5.Нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлтэй авто зогсоолуудын системүүдийг Зам, тээврийн нэгдсэн системд холбох, авто зам дагуух замд түр буюу удаан зогсохыг хориглосон тэмдэгтэй зам дээр тээврийн хэрэгсэл байршуулсан үед торгох төлбөрийн системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), Замын хөдөлгөөн удирдлагын төв ОНӨТҮГ (С.Адъяасүрэн)-т, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг) Нийслэлийн татварын газар (Д.Батжаргал нарт)-т;

6.Зам, тээврийн нэгдсэн систем бий болсонтой холбогдуулан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг холбогдох чиг үүргийн байгууллагаар хийлгэх, мэдээллийн аюулгүй

байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т;

7.Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн зөрчил илрүүлэх чиглэлээр шинээр суурилуулсан телехяналтын камеруудыг нутагшуулах, хэвийн үйл ажиллагааг хангах, торгуулийн системтэй холболт хийж хэрэглээнд нэвтрүүлэхийг Замын хөдөлгөөн удирдлагын төв ОНӨТҮГ (С.Адъяасүрэн)-т, Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т;

8.Нийслэлийн автотээврийн шалган нэвтрүүлэх товчоодын цахим төлбөрийн системийн хэвийн үйл ажиллагааг хангахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т, товчоодын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай зардлыг жил бүрийн нийслэлийн замын сангийн төсөвт тусгаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан)-т;

9. Нийслэлийн гэрлэн дохиотой уулзваруудад суурилуулагдсан RFID TAG уншигч төхөөрөмж болон камеруудын ашиглалт, хамгаалалт засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг жил бүрийн нийслэлийн төсөвт тусгахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т;

10.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID TAG/-г суурилуулахтай холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т, холбогдох чиг үүргийн байгууллагуудын удирдлагуудад;

11.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ суурилуулахтай холбоотой дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангаж хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангахыг Замын хөдөлгөөн удирдлагын төв ОНӨТҮГ (С.Адъяасүрэн)-т, системийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т;

12.Зам, тээврийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хэвийн найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр санхүүжүүлэх боломжийг судалж танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс (Д.Алтангэрэл), Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар (О.Чинзориг)-т;

13."Зам, тээврийн нэгдсэн систем" төслийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн)-д тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТТБ№2105